



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн давтан аудитын тайлан.

“СЭЛЭНГЭ ЭНЕРГО” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ДАВТАН АУДИТ

Техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн үе шат бүрийг автоматжуулан, хяналт, үр ашгийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авсан ч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, удирдах албан тушаалтнуудын шатахууны зарцуулалтыг хянах талаар өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй байна.



Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Аудитор

А.Дашбат

2017 оны 10-11 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
7036-2442 дугаарын
утас, 7036-3040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар
сум аймгийн ЗДТГ-
ын байрны
өргөтгөлд

Агуулга

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Хоёр. Үндсэн мэдээлэл
Гурав. Аудитын дүн

Бүлэг 1: Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан уу ?

- 1.1. Өмнөх аудитаар тавигдсан актыг бүрэн барагдуулсан уу?
1.2. Албан шаардлагын биелэлтийг хангаж, зөрчлийг таслан зогсоосон эсэх?

Бүлэг 2: Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу ?

- 2.1. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү?
2.2. ОНӨААТҮГ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч нарт өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

НББ	Нягтлан бодох бүртгэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДХТ	Дулаан хуваарилах төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр: “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд хийх давтан аудит.

2.Аудитын код: СЭА-2017/01/-ГА-ДА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилт:

2016 онд “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ❖ Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан уу ?
- ❖ Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу ?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитыг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар тавигдсан акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг, 2016 оны 9 сараас 2017 оны 8 сар хүртэлх үйл ажиллагааг хамруулан шалгав.

6.Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7.Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- ТБОНӨХБАҮХАТ хууль
- Компанийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор А.Дашбат 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

9.Үндсэн мэдээлэл:

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-нь өнөөгийн байдлаар KE-25/14 маркийн 3, KBTC-20/150 маркийн 1, DZL-2.8-н 1 зуухтай, 40 км төв ба салбар шугамтай, 7 дулаан хуваарилах төвтэйгээр дулааны станц, дулааны шугам сүлжээ, захиргаа аж ахуй гэсэн 3 үндсэн хэсэгт 116-120 ажилтан ажиллаж, жилд дундажаар 37.0 мян.тн нүүрс, 2.8 сая квт/ц цахилгаан эрчим хүч, 158 мянган м3 ус хэрэглэж байна.

Тус үйлдвэрийн газрын захирлаар Ш.Оргил 2009 оноос 2016 оны 04 дүгээр сарын 01 хүртэл, түүнээс хойш одоог хүртэл Э.Эрдэнэбаатар, нягтлан бодогчоор Д.Ванчигмаа 2011 оноос хойш ажиллаж, хөрөнгө, мөнгө зарцуулах 1, 2-р гарын үсгийг зурж байна.

2016 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар 11.0 сая төгрөгийн авлага барагдуулах акт, 1,980.4 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага, үр өгөөж, үр ашиг, арвилан хэмнэлтийг дээшлүүлэх 5 зөвлөмжийг захиралд, 3 зөвлөмжийг нягтлан бодогчид өгсөн байна.

БҮЛЭГ:1

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан уу ?

Өмнөх аудитаар тавигдсан актын биелэлт 100,0 хувьтай бол албан шаардлагын **биелэлт 89,0 хувьтай** байна.

1.1 Өмнөх аудитаар тавигдсан актыг бүрэн барагдуулсан уу ?

Акт

- Байгууллагын ажилчидтай холбоотойгоор 2011 оноос хойш үүссэн 11,001.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах.

Тус актын дагуу нийт 104 ажилчидтай холбоотой үүсэн авлагыг бүрэн барагдуулж, ОНӨААТҮГ-ын захирлын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 308 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаас хойш тус үйлдвэрийн газар нь 2017 оны 08 дугаар сарын байдлаар хугацаа хэтэрсэн 3 хүний 1,583.4 мянган төгрөгийн /2016 онд олгосон 6 хүний сургалтын төлбөрийн зээлээс 3 хүний зээлийн хугацаа хэтэрсэн/, хугацаа нь болоогүй 30 хүний 5,033.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Актын биелэлт **100,0** хувь гэж үзэж байна.

1.2 Албан шаардлагын биелэлтийг хангаж, зөрчлийг таслан зогсоосон эсэх ?

Өмнөх аудитаар дараах албан шаардлага өгөгдсөн байна. Үүнд:

- 1. Бараа материалын дансанд 11 нэр төрлийн 12,379.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн зөрчлийг залруулах.**

Тус үйлдвэрийн газрын захирлын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 308 дугаар албан бичгээр “Албан шаардлагын дагуу бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг залруулж үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн” гэсэн хариуг ирүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	Материалын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /мян.төг/	Залруулагдсан эсэх
1	Гагнуурын редуктор	1	7,800.0	7,800.0	Тийм

2	Насос КР-85	1	137.3	137.3	Тийм
3	Нэмэлт усны насос к-30-45 моторгүй	1	350.0	350.0	Тийм
4	Таслагч KEV	5	86.0	430.0	Тийм
5	Шүршигч насос /улаан/	1	60.0	60.0	Тийм
6	UPS 650VA тог баригч	1	229.0	229.0	Тийм
7	Дурантай аппарат	1	198.6	198.6	Тийм
8	Канон	1	1,500.0	1,500.0	Тийм
9	Тог баригч	5	160.0	800.0	Тийм
10	Ширээ	1	125.0	125.0	Тийм
11	Шкаф 2 хаалгатай	3	249.9	749.7	Тийм
Нийт дүн				12,379.6	

Мөн 2016 оны 09 дүгээр сараас 2017 оны 08 дугаар сарын хооронд 12,185.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 12,900.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 173,043.9 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 22,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 5,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, нийт 225,628.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсныг НББ-ийн стандартын дагуу үнэн зөв бүртгэж ажилласан байна. Уг албан шаардлагын хэрэгжилт **100,0** хувь байна.

2. Гэрээ зэрэг анхан шатны баримтгүйгээр болон нүүрс олборлох үйл ажиллагаа явуулдаггүй компаниудаас нийт 19,832.3 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх.

Албан шаардлагын хүрээнд тус үйлдвэрийн газрын 2016 оны 09 дүгээр сараас 2017 оны 08 дугаар сарын нүүрсний худалдан авалттай холбоотой анхан шатны баримт, материалтай танилцаж шалгахад нийт 5 компаниас 1,125,732.8 мянган төгрөгийн, 2 иргэнээс 2,649.9 мянган төгрөгийн нүүрс тус тус худалдан авсан байна.

Нүүрсний худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгчээр нь задалж харуулбал:

№	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Он. Сар	х/н	Хэмжээ	Дүн /мян.төг/
1	Шарын гол ХК	2016.09-12 сар	тн	10922.55	398,673.1
2	Ред хил ХХК	2016.09-12 сар	тн	1304.35	19,565.3
3	Пүрэвхаан ХХК	2016.09-12 сар	тн	195	5,226.0
4	Баянхаан БМД	2016.09-12 сар	тн	45	2,025.0
6	Шарын гол ХК	2017.01-08 сар	тн	10,993	401,253.6
7	Ред хил ХХК	2017.01-08 сар	тн	17,358	280,706.2
8	Сэлэнгэ тэнгэр Хараа ХХК	2017.01-08 сар	тн	662	16,033.6
9	Баянхаан БМД	2017.01-08 сар	тн	50	2,250.0
10	Иргэн Баяраа	2017.01-08 сар	тн	54	2,168.1
11	Иргэн Н.Бат-Очир	2017.01-08 сар	тн	13	481.8
Нийт дүн				41,597.45	1,128,382.7

Дээрх хүснэгтээс харахад нүүрс олборлох үйл ажиллагаа явуулдаггүй 2 иргэн, 3 компаниас нийт 28,184.5 мянган төгрөгийн нүүрс худалдан авч албан шаардлагыг **97,5** хувиар биелүүлсэн байна.

3. 1,948,166.1 мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авалтын гүйцэтгэгчийг үнийн харьцуулалт хэрэглэлгүйгээр шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

2016.09-2017.09 сар хүртэл 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний жагсаалтыг хүснэгтээр харуулбал:

№	Бараа материалын нэр	х/н	тоо хэмжээ	Нэгж үнэ /мян.төг/	дүн /мян.төг/	Хугацаа	ХАА зохион байгуулсан эсэх
1	НАСОС 220/230-50/60HZ	ширхэг	2	9,500.0	19,000.0	2016.09-12	үгүй
2	Давтамж хувьсгуур 110 квт	ширхэг	1	25,000.0	25,000.0	2016.09-12	үгүй
3	Ялтсан бойлер 1мвт	ширхэг	2	7,500.0	15,000.0	2016.09-12	үгүй
4	Дулааны алданги хэмжигч	ширхэг	1	15,000.0	15,000.0	2016.09-12	үгүй
5	Плазм-G-KB-100	ширхэг	1	18,000.0	18,000.0	2017.01-08	үгүй
6	Nissan hino маркын автомашин	ширхэг	1	22,500.0	22,500.0	2017.01-08	үгүй
7	Шарын гол ХК нүүрс	тн	10993.25	36.5	401,253.6	2017.01-08	тийм
8	РЕД ХИЛЛ Монголиа ХХК нүүрс	тн	17358.1	5.0-72.7	280,706.3	2017.01-08	тийм
9	Дулаан станцын агааржуулалтын системийн ажил-Гүйцэтгэгч Вест Бюлдинг ХХК	Багц	1	15,404.1	15,404.1	2017.01-08	үгүй
10	Автоматжуулах системийн ажил гүйцэтгэх гэрээ-гүйцэтгэгч Эликтрик смарт мониторинг ХХК	Багц	1	29,980.0	29,980.0	2017.01-08	тийм
11	Труба ф51-Сэлэнгэ титан	метр	4267	15.0	64,000.0	2017.01-08	үгүй
12	Галын тоосго	ширхэг	2400	4.9	11,700.0	2017.01-08	үгүй
13	Шатахуун	литр	54558	1.3-1.5	82,122.1	2017.01-08	үгүй
14	Конвейрийн жин нийлүүлж, угсарч	багц	1	22,550.0	22,550.0	2017.01-08	үгүй

суурилуулах ажил- Гүйцэтгэгч-ПЭХЭМ ХХК						
Нийт дүн				1,022,216.1		

Хүснэгтээс харахад нийт сонгон шалгаруулалт зохион байгуулах ёстой 14 бараа, ажил, үйлчилгээнээс Автоматжуулах системийн ажлын гүйцэтгэгчийг захирлын тушаалаар байгуулагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөл” зохион байгуулсан бөгөөд Эрчим хүчний зохицуулах хороо, “Шарын гол” ХК-д хүсэлт илгээсний үндсэн дээр тус компанитай гэрээ байгуулж, Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудад олгодог хөнгөлөлттэй үнээр буюу 3700 К/кал илчлэгтэй нүүрс худалдан авсан бол үнийн харьцуулалт хийсний үндсэн дээр РЕД ХИЛЛ Монголиа ХХК –иас тн тутмыг нь 37,0 мянган төгрөгөөр, нийт 280,706.3 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна.

Дээрх 3 худалдан авалтаас бусад шууд худалдан авах босго үнээс давсан 310,276,2 мянган төгрөгийн худалдан авалтын гүйцэтгэгчийг хуулийн дагуу зохион байгуулаагүй буюу албан шаардлагын хэрэгжилт **69,6** хувьтай байна.

БҮЛЭГ:2

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад өгсөн зөвлөмж **91,2** хувьтай, байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогч нарт өгсөн зөвлөмж **84,4** хувьтай хэрэгжиж байна.

2.1 Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг дарга нарт :

Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад хамаарах 8 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт зөвлөмжийн биелэлтийг аймгийн Засаг даргын 2017 оны 05-р сарын 31-ний өдрийн 1/566 дугаар, ЗДТГ-ын даргын 2017 оны 9-р сарын 12-ны өдрийн 2/393, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2017 оны 06-р сарын 13-ны өдрийн 152, 2017 оны 09-р сарын 15-ны өдрийн 194 дүгээр албан бичгээр тус тус ирүүлсэн байна. Үүнд:

1. “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын захиралтай жил бүр гэрээ байгуулж, дүгнэж байх.

Тус зөвлөмжийн дагуу 2017 оны үр дүнгийн гэрээг 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн Засаг дарга Ш.Оргилтой байгуулан ажиллаж байна.

Тус гэрээгээр зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2 талын эрх, үүрэг, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүрэх түвшин, орон нутгийн өмчийн газрын эрх, эд хөрөнгийн хариуцлага, гэрээний биелэлтийг дүгнэх журам, хугацааг нарийн тодорхой зааж өгсөн бөгөөд уг зөвлөмж **100,0 хувь** хэрэгжсэн байна.

2. “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-т зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлэх, техник технологийг шинэчлэх арга замыг хайх.

Тус зөвлөмжийн дагуу биелэлтийг аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/566, 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 2/393 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн бөгөөд Сүхбаатар сумын 7-р багт хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах, мөн 7-р багт дулаан хуваарилах сувгийн засварын ажил хийж, шинээр ашиглалтад орсон усан бассейны дулааны шугамын зэрэг ажлуудыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж ажилласан байна.

Ун зөвлөмжийг **бүрэн** хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

3. Шаардлагатай гэж үзвэл тус үйлдвэрийн газрыг холбогдох яаманд харьяалуулж, мэргэжлийн удирдлагаар хангуулах арга хэмжээ авах.

Зөвлөмжийн дагуу аймгийн ИТХ-аас Эрчим хүчний яаманд тус ОНӨААТҮГ-ыг харьяа яаманд нь харьяалуулж, ажиллуулах талаар албан бичгээр удаа дараа хандсан боловч Эрчим хүчний яаманд харьяалагдахад дулааны станцын дулаан үйлдвэрлэх хүчин чадал нь жилд 68.7 гкалл дулаан түгээж байгаа тул үйлдвэрлэсэн дулааны хэмжээ яамны харьяа болоход хүрэлцэхгүй байна гэсэн шалтгаанаар төрийн өмчит үйлдвэрийн газар болгох боломжгүй гэсэн хариу өгсөн байна. Зөвлөмжийн **хэрэгжилт 100,0 хувьтай** байна.

4. Орон нутгийн төсөвт төлөх 744,446.2 мянган төгрөгийн өглөгийг тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнгээс төлөх боломжгүй байгаад дүгнэлт хийж, данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх.

Зөвлөмжийн дагуу аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотыг дулаан, хэрэглээний усаар хангадаг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны доголдлыг арилгах, өр зээлийн хэмжээг багасган, санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2004-2008 онуудад аймгийн төсвөөс нүүрс, ус, цахилгааны төлбөрт зориулан зарцуулсан 744,462,230 төгрөгийн өр, авлагыг хүчингүй болгож төсвийн алдагдалд тооцсугай” гэсэн шийдвэр гарч, хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийн, данс бүртгэлээс хассан байна. **Зөвлөмжийн хэрэгжилт 100,0 хувь.**

5. “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг авах.

Аймгийн ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан ОНӨААТҮГ-уудын тухайн жилийн үйл ажиллагааны тайланг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, санхүү,

төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, үүрэг, чиглэл өгч ажиллаж байгаа талаар аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 152 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн байна. Зөвлөмжийн **хэрэгжилт 100,0 хувь**.

6. Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар баталж, гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавих.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргатай 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байгаа боловч тус гэрээний 3 дугаар зүйлийн 3.1-д *"Захирал нь үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөөг орон нутгийн өмчийн газраар батлуулан, биелэлтийг хангаж ажиллана"* гэж заасныг зөрчин 2017 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг ОНӨААТҮГ-ын захирал өөрөө батлан ажиллаж байна.

Харин үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө нь тооцооллын хувьд өмнөх жилтэй харьцуулахад бодит тооцоо судалгаан дээр үндэслэсэн байна. Гол ялгааг тодруулбал:

№	2016 оны Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө	2017 оны Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө
1	Борлуулалтын орлогын төлөвлөгөөг өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэл дээр үндэслэн тооцдог байсан.	Борлуулалтын орлогын төлөвлөгөөг хэрэглэгчдийн тоон судалгаа, мэдээлэл дээр үндэслэн 12 сараар тооцоо хийдэг болсон.
2	Зардлын төлөвлөгөөг цех, тасаг бүрээр урьд оны зардлын гүйцэтгэл дээр үндэслэн тооцдог байсан.	Инженерүүдээс үйлдвэрлэлийн тооцоолол, шаардлагатай материалын захиалгыг авч, түүн дээр үндэслэн зардлын эдийн засгийн ангилал бүрээр дэлгэрэнгүй тооцоолол хийдэг болсон.
3	Техник эдийн засгийн төлөвлөгөө боловсруулж үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөндөө тусгадаггүй байсан.	Техник эдийн засгийн төлөвлөгөө боловсруулдаг болсон.
4	Их засварын зардлыг зөвхөн урьд оны гүйцэтгэл дээр үндэслэн тооцдог байсан.	Их засварын график төлөвлөгөө гаргасны үндсэн дээр захиалга өгсөн инженер бүрээр зардал тооцож, нарийн тооцоо судалгаатай төлөвлөгөө боловсруулдаг болсон.

Зөвлөмжийн биелэлт **80,0 хувь** гэж дүгнэж байна.

7. Төсөвт байгууллагуудаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Тус зөвлөмжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 2/393 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд аймгийн Засаг даргын зүгээс "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ-ын төсөвт байгууллагуудаас авах авлагыг төсөвт байгууллагатай тооцоо нийлж тухайн тооцооны үлдэгдлээр алданги тооцох мэдэгдэл өгөн, харьяа яаманд нь төсвийн тодотголоор оруулж тухайн жилд өр төлбөрийг барагдуулж байна гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 314 дугаар албан бичгээр 3 дугаар улирлын байдлаар өр, авлагаа хэрхэн

барагдуулж байгаа талаар тайлан авсан байна. Тус тайлангаар авлага оны эхнээс 49,435.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй мэдээлсэн бөгөөд өглөг барагдуулж ажилласан талаар тайлан ирүүлээгүй байна.

2017 оны 08 дугаар сарын төсөвт байгууллагуудаас авах авлагыг хүснэгтээр харуулбал:

№	Харилцагч код, нэр	2016 оны жилийн эцэс	Нэмэгдсэн	Хасагдсан	2017 оны 08 сарын 30-ны байдлаар
1	12-н жилийн 4-р сургууль		55,191.1	52,786.5	2,404.6
2	2-р цэцэрлэг		68,384.9	61,003.4	7,381.5
3	3-р цэцэрлэг		43,713.1	35,463.1	8,250.0
4	4-р цэцэрлэг		29,819.0	27,653.2	2,165.8
5	Аймгийн тамгийн газар		62,907.1	61,996.3	910.8
6	Прокурор		14,916.9	12,475.0	2,441.9
7	Сэлэнгэ долгио чуулга		89,263.6	72,424.3	16,839.3
8	Онцгой байдлын хэлтэс	1,849.1	37,917.8	27,447.1	12,319.8
9	Цагдаагийн газар		48,050.6	36,389.7	11,660.9
10	Аймгийн нэгдсэн эмнэлэг		339,119.1	263,472.4	75,646.7
11	ХАА-н газар		5,592.3	4,988.6	603.7
12	ЗӨСТөв		6,883.9	6,007.7	876.2
13	Мах боловсруулах үйлдвэр	4,767.1	4,406.8	9,173.9	
14	Боловсрол соёл урлагийн газар	1,610.0	9,302.6	10,912.6	
15	СБ сумын байр-ПСМК-8-р баг	16,148.5	9,047.2	6,970.0	18,225.7
16	Нийгмийн халамж үйлчилгээ-Хялганат Нуга	4,326.2	24,701.4	24,701.4	4,326.2
17	Сэлэнгэ Номгон Өрхийн эмнэлэг		2,004.0		2,004.0
18	Шинэ 3-р сургууль	97,576.6	64,128.1	64,128.1	97,576.6
19	Нутгийн захиргаа 2-р байр		50,173.0	44,757.8	5,415.2
20	Олон улсын худалдааны төв	5,000.0	27,526.0	30,526.0	2,000.0
21	Усан бассейн	7,529.1	41,066.8	48,595.9	
	Нийт дүн	138,806.6	1,034,115.3	901,873.0	271,048.9

Дээрх судалгаанаас харахад 2017 оны эхний 8 сарын байдлаар нийт авлага 2016 оны жилийн эцсийнхээс 95,3 хувиар өссөн бөгөөд авлагын 63,9 хувийг аймгийн нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын бүрэн дунд 3-р сургууль эзэлж байна.

3-р сургуулийн хувьд тус сургуулийн барилга ашиглалтад орж, комисс хүлээж авах хүртэл 2013-2014 онуудад тооцогдсон дулааны төлбөр төлөгдөөгүйн улмаас үүссэн авлага бол аймгийн нэгдсэн эмнэлгийн хувьд 2016 оны 11 сард Ф100 труба-г Ф250 трубаа болгон сольсноос үүссэн авлага байна.

Тодорхой хэмжээний арга хэмжээ авсан ч үр дүн гараагүй тул уг зөвлөмжийн биелэлт 50,0 хувьтай байна гэж дүгнэж байна.

8.Эрчим хүчний сайдын 2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” 122 дугаар тушаалаар баталсан халаалтын улирлын хугацааг баримталж ажиллах.

Эрчим хүчний сайдын 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тушаалаар халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг 09 дүгээр сарын 15-наас дараа оны 05 дугаар сарын 15-ны хүртэл тогтоож өгсөн байна.

Тус тушаалын дагуу 2017-2018 онд халаалт авах 286 ААН, 1664 төвлөрсөн орон сууц, 562 хувийн орон сууц, 44 төсөвт байгууллага зэрэг нийт 2556 хэрэглэгчээс 2017 оны 09 сарын байдлаар 1891 хэрэглэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд халаалтыг дээрх хугацаанд нийлүүлэхээр тусгагдсан учир зөвлөмж **100,0 хувь** хэрэгжсэн гэж үзэж байна.

2.2 ОНӨААТҮГ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч нарт өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

“Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ОНӨААТҮГ-ын захирал Э.Эрдэнэбаатарт дараах зөвлөмжүүд өгөгджээ Үүнд:

1. Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн зөвхөн хөрөнгө материалыг данснаас хасах акт тогтоох бус худалдан авалт, ашиглалтад бодитой хяналт тавьж ажиллуулах.

Захирлын 2017 оны 05 сарын 09-ний өдрийн 55 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан боловч зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж , хэрэгжүүлээгүй байна.

Тус зөвлөл нь 2017 оны 1, 3, 4, 6 саруудад 5 удаа хуралдахдаа 2016 оны байгууллагын жилийн эцсийн тооллогыг үндэслэн актлах саналтай хөрөнгүүдийг хэлэлцэх, конвейрын жин, автоматжуулалтын систем, агааржуулах системүүдийг худалдан авах, шугам сүлжээний хэсгийн зуны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлуудыг хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байгаа нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн үндсэн үүргийг гажуудуулж, дотоод хяналтыг сулруулах үр дагаврыг бий болгож байна. Цаашид “Өмч хамгаалах байнгын зөвлөл” –ийн ажиллах журмыг боловсруулж, мөрдөн ажиллах нь зүйтэй бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт **80,0** хувьтай гэж дүгнэж байна.

2. Алдагдлыг багасгах, ашигтай ажиллах нөхцөл боломжийг судалж, тодорхой үр дүнтэй арга хэмжээг авах.

Алдагдлыг бууруулах арга замыг тодорхойлох зорилгоор 2017 онд инженер, техникийн ажилтнуудын дунд бүтээлч уралдаан зарлан шалгаруулсны үндсэн дээр арилжааны банкны зээлийн эх үүсвэрээр 29,980.0 мянган төгрөгийн автоматжуулалтын системийн ажил, 22,550.0 мянган төгрөгийн конвейрийн жин нийлүүлж, угсарч суурилуулах ажил, 15,404.1 мянган төгрөгийн агааржуулалтын системийн ажлуудыг гүйцэтгүүлсэн бөгөөд өөрсдийн дотоод нөөц бололцоогоо дайчилж дараах их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- **Дулааны станцын засварын хэсэгт:** Зуух №1-ийн утаа сорогч салхины хоолойг шинэчлэн засварласан, ухаалаг насос суурилуулсан, редукторыг бүрэн задалж, угсарсан бусад урсгал засвар, зуух №2-ын агаар халаагч, батерейн циклон, утааны замыг задалж үзлэг, засвар хийсэн, зуух №4-ийн ул ширэмний редукторыг бүрэн задалж, хурдны хайрцаг, могой арааг сэргээн засварлаж зуух №1-д угсарсан, зуух №5-ын агаар халаагчид насадка, нарийн үнсний бункер, утаа сорогч, салхилуур болон хаалт арматурт засвар, сүлжээний насоснуудад урсгал засвар хийсэн.
- **Дулааны станцын ашиглалтын хэсэгт:** Зуух №2, 5 –ын битүүрсэн хоолойнуудын бөглөөсийг гаргаж, гэмтэлтэй хоолойнуудыг гагнаж, 48 ш насадка хийсэн, зуух №2-т шинээр 10 ш хоолой гагнасан, станцын ерөнхий шугамын болон салаа 1, 2-н тоолуурын датчикиг сольсон, дулааны станцын дотор шугам хоолойд дулаалга хийсэн.
- **Түлш дамжуулах, Авто хэсэгт:** 180 метр дулааны шугамын суваг ухаж блокоор лотки хийж шугамаа татаж дулаалан таглан, 1 ш худаг хийсэн, түлш дамжуулах хэсгийн тоноглолын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн, 1000 ш лоткины тагийг өөрсдийн хүчээр цутгаж хийсэн.
- **Цахилгааны хэсэгт:** **Тр-уудын** гаргалгаа болон **шинна**, автоматчуудын оруулгад чангалгаа хийсэн, гагнуур болон хуваарилах шитүүдэд засвар хийсэн, **ТЗДХТ-н** хүчдэлгүй болсон байсныг гэмтлийг олж засварласан, ДХТ-1 гэрэлтүүлгийн монтаж засвар хийсэн, СН-17 автомат сольсон, түлш дамжуулахын цахилгаан тоноглолд үзлэг засвар хийж ажиллагаанд бэлэн болгосон, ЯЧ-№12 хүчдэлд залгасан.
- **Нарийн хэмжүүрийн хэсэгт:** 1,2-р салаанд болон Зуух №1,2,4-т температурын датчик, зарцуулалтын датчик суурилуулсан, дулаан хуваарилах төв №1,3, ТЗДХТ-үүдэд температурын датчик суурилуулж, сүлжээнд холбож нэгдсэн хяналтаар серверээр хянах боломжтой болсон, түлш дамжуулах туузан дамжлаг дээр жин хэмжүүр суурилуулсан, дулааны станц дулааны шугам сүлжээний хэмжих хэрэгсэл, манометруудад засвар үйлчилгээ хийж тавьсан.
- **ДШС-ний засвар, ашиглалтын хэсэгт:** Хэрэглээний халуун усны шугамд засвар үйлчилгээ хийсэн, УТ-6 салааны 40 гаруй айлын 126 метр хос шугамыг ф-120 диаметртэй болгон томруулан шинэчлэн, сувгийн шалыг цутган зориулалтын цутгамал лотки таг тавьж, дулаан усны алдагдалгүй болгосон, дулаан хуваарилах төв-1-ээс цэнхэрийн 18-р байрны худаг хүртэлх 80 м дулааны болон **ХХУ-ны** шугамыг шинээр сольсон, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хаалтуудыг бүгдийг нь сольсон, **ЦТП-6**, худаг-№1-4 хүртэл 100 метр хос дулааны шугамыг шинээр сольсон, дулаан алдагдал ихтэй байсныг зориулалтын лотки таг тавьж стандартын дагуу дулаалсан байна.


Мөн эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний дагуу 14 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 9 сарын байдлаар 10 ажлыг хийж, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8-н ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тус ажлын хүрээнд:

- Техникийн нөхцөлгүй дур мэдэн холболт хийсэн айл өрх, ААНБ, буруу холболт хийсэн болон хий авагчийн оронд цорго холбож усны алдагдал гаргаж байгаа хэрэглэгчдийг илрүүлж, стандартын дагуу холболт хийлгэсэн.
- Шугам хоолойн насжилтыг тодорхойлсон.
- Хэрэгчлэгчдийн өр, авлагын үлдэгдэл болон барилгын эзлэхүүний тулгалт хийсэн.
- Гадна шугамын хаалт, сувагжилтын судалгаа авсан.

- Хэрэглэгчдийн дулаан алдагдлыг хэмжих, заавар зөвлөгөө өгсөн байна.

Уг шалгалтын ажлын үр дүнд айл өрх, ААНБ нийлсэн 885 хэрэглэгчээс 361 хэрэглэгч зөрчилтэй гарсны дагуу 2017 оны 06 дугаар сарын 01-нээс 2017 оны 10 дугаар сар хүртэл хэрэглэгчдэд албан шаардлага хүргүүлж, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллажээ.

Тус хөрөнгө оруулалт, их засварын ажлын дараах үйлдвэрлэлийн үзүүлэлтийг өмнөх жилүүдийн мөн үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулан графикаар харуулбал:



Дээрх графикуудаас харахад дулаан үйлдвэрлэлт 2016 оны мөн үеэс 22.2 хувиар өссөн байхад нүүрсний зарцуулалт 2015 оны мөн үеэс 53.2 хувиар, 2016 оны мөн үеэс 35.2 хувиар, дулааны станцын цахилгааны зарцуулалт 2015 оны мөн үеэс 79.8 хувиар, 2016 оны мөн үеэс 74.6 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байхад дулааны шугам сүлжээний цахилгааны зарцуулалт 2015 оны мөн үеэс 25 дахин, 2016 оны 9 сарынхаас 15,8 дахин өссөн байгаа нь 2017 оны 06 дугаар сараас эхлэн ТЗ, дулаан хуваарилах төвүүдэд 24 цагийн ажиллагаатай цахилгаан бойлер суурилуулсантай холбоотой байна.

2017 оны хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

№	Үзүүлэлт	2016 оны хагас жил	2017 оны хагас жил	Өсөлт (бууралт)
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,965,510.6	2,389,780.9	424,270.3

2	ББӨ	2,589,874.8	2,612,095.4	22,220.6
3	Нийт ашиг (алдагдал)	(624,364.2)	(222,314.5)	(402,049.7)
4	Хүүгийн орлого	188.6	391.6	203.0
5	Бусад орлого	165,853.2	189,278.5	23,425.3
6	Ерөнхий ба удирдлагын зардал	83,627.4	111,388.5	27,761.1
7	Санхүүгийн зардал		3,311.3	3,311.3
8	Бусад зардал	7,115.0	53,465.1	46,350.1
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(549,064.8)	(200,809.3)	(348,255.5)

Дээрх хүснэгтээс харахад алдагдал өмнөх оны мөн үеэс 348,255.5 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 424,270.3 мянган төгрөгөөр буюу 21.6 хувиар өссөнтэй холбоотой юм.

Сүхбаатар сумын орон сууцны хуучин барилга болох захын-21, 22, 23, 25-р байр /1970-1971 онд баригдсан/, барилгын 24-р байр /1968 онд баригдсан/, Б-27-р /1970 онд баригдсан/ байруудын дотор инженерийн шугам сүлжээ муудсан, зарим айл, албан газрууд нь дулааны шугам хоолойг дур мэдэн өөрчилсөн зэргээс шалтгаалж айл өрх, албан газрууд нь халахгүй байна гэсэн шалтгаанаар паарны усыг ОО-ын өрөөний суултуурын бохирын хоолой руу /шланкаар холбож/ 24-н цагийн турш өртөг шингэж халаасан усыг шууд асгаж байгаа бөгөөд тэр хэмжээгээр усны алдагдал нэмэгдэж, усны зардал өссөн байна.

Тус үйлдвэрийн газар нь зөвлөмжийн дагуу техникийн шинэчлэл хийж, автоматжуулалтын системтэй болж чадсанаар үйлдвэрлэлийн үр ашиг, цаашлаад эдийн засгийн үзүүлэлтэд эерэг нөлөө гарч эхэлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт **100,0 хувьтай** байна гэж дүгнэж байна.

3. Нүүрсний нөөцийг дулаан үйлдвэрлэлийн горимд заасан хэмжээнд байлгах, нүүрсийг үйлдвэрлэгчээс шууд бэлтгэн нийлүүлэх.

Дулаан үйлдвэрлэлийн горимд сарын 5000-6000 тн нүүрсний нөөцтэй байхаар тогтоосон байдаг боловч алдагдалтай ажиллаж байгаагаас нүүрс нөөцөлж чаддаггүй байдал оршиж байна. Нүүрсийг тогтоосон хэмжээнд нөөцөлж чаддаггүйгээс 2017 оны 1 дүгээр сарын 26-нд иргэн н.Бат-Очирос 481.8 мянган төгрөгийн, 2 дугаар сарын 28, 4 дүгээр сарын 30-нд Сэлэнгэ тэнгэр Хараа ХХК-аас нийт 35,935.2 мянган төгрөгийн, мөн 4 дүгээр сарын 30-нд Баянхаан барилгын материалын дэлгүүрээс 2,250.0 мянган төгрөгийн, иргэн н.Баяраагаас 2,168.1 мянган төгрөгийн нүүрс тус тус худалдан авсан байна.

Харин 2017 оны 05 сард өөрийн хөрөнгөөр “Конвейрийн жин нийлүүлж, угсарч суурилуулах ажил”-ыг “ПЭХЭМ” ХХК-аар гүйцэтгүүлж, SCHENCK MULTIBELT ВЕР06 маркийн жин хэмжүүр ашиглалтад оруулснаар зууханд хэрэглэж байгаа нүүрсний зарцуулалтыг хянах, бодитойгоор тооцох боломжтой болсон байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг **100,0 хувь** гэж үзэж байна.

Жин хэмжүүрийн нүүрсний зарцуулалтыг тооцож байгааг зураг №1-т харуулав.



2017 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ныг хүртэл хугацаанд хэрэглэсэн нүүрсний зарцуулалт 2395 тн, тухайн цаг үед функерт байгаа нүүрсний хэмжээ 21.9 тн байгаа нь зураг №1-т харагдаж байна.

4. Өөрийн хэрэгцээнд бэлтгэн нийлүүлсэн нүүрсийг гадны компани, иргэдэд борлуулах үйл ажиллагааг зогсоох.

2016 оны 09 сараас 2017 оны 08 дугаар сарын харилцах, касс, нүүрсний тайланг шалгахад өөрийн ажиллагсад болох 24 иргэнд 2,644.0 мянган төгрөгийн, 6 байгууллагад 5,544.0 мянган төгрөгийн нүүрс борлуулсан байна.

6 байгууллагад хийгдсэн борлуулалт нь аймгийн Засаг даргын албан даалгавар, аймгийн Онцгой комиссын албан бичгийн дагуу зайлшгүй тохиолдолд хийгдсэн бөгөөд уг борлуулалтаас үйлдвэрийн газар ямар нэгэн хохирол хүлээгээгүй учир / 1 тн нүүрсний өртөг 47,0 мянган төгрөг бол 80,0 мянган төгрөгөөр борлуулсан / зөвлөмжиг **100,0 хувь** биелүүлсэн гэж үзлээ.

Гадны байгууллага, иргэдэд борлуулсан нүүрсний борлуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Он. Сар	х/н	Хэмжээ	Орлогын дүн /мян.төг/
1	12 Иргэн	2016.09-12 сар	тн	14	1,020.0
2	МОН ЖИМ ХХК	2016.09-12 сар	тн	23.1	1,848.0
3	Шаамар ЗДТГ	2016.09-12 сар	тн	19.2	1,936.0
4	ХААГазар	2016.09-12 сар	тн	9	720.0
5	Шаамар 1-р цэцэрлэг	2016.09-12 сар	тн	3	240.0
6	12 Иргэн	2017.01-08 сар	тн	21.05	1,624.0
7	Асгатын дов ХХК	2017.01-08 сар	тн	5	320.0
8	ХААГазар	2017.01-08 сар	тн	1	80.0
9	Хилийн цэргийн 0101-р анги	2017.01-08 сар	тн	5	400.0
Нийт дүн				100.35	8,188.0

Ерөнхий нягтлан бодогч Д.Ванчигмаад.**1. Нягтлан бодох бүртгэлийг НББ-ийн тухай хууль болон НББОУС-д нийцүүлэх.**

Тус ОНӨААТҮГ нь 2009 онд “Актив-аудит” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн салбарын боловсруулсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон 2016 оны жилийн эцсийн, 2017 оны хагас жилийн санхүүгийн тайланг аккурель сууриар үнэн зөв бүртгэж байна.

Зөвлөмжийн хэрэгжилт **100,0** хувьтай байна.

2. Авлага, өглөгийн үлдэгдлийг тайлант хугацаа бүрийн төгсгөлд тооцоо нийлж, баталгаажуулан, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.

Тус үйлдвэрийн газар нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 580,070.5 мянган төгрөгийн дансны авлага, 3,304,363.8 мянган төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж байсан бол 2017 оны эхний хагас жилийн байдлаар 900,951.2 мянган төгрөгийн дансны авлага, 2,755,923.8 мянган төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, авлага 55,3 хувиар өсч, өглөг 16,6 хувиар буурсан байна.

Аудитаар тус үйлдвэрийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан өр, авлагыг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад нийт 65 харилцагчтай тооцоо нийлэхээс 9 харилцагчтай тооцоо нийлээгүй, 4 газартай тооцоо нийлсэн ч харилцагч байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулаагүй байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчиж байна.

Зөвлөмжийн биелэлт **81,0** хувьтай байна.

3. Удирдлагын шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримт, маршрут, ажлын удирдамжийн дагуу шатахуун зарцуулах, шатахууны хэрэглээний норм тогтоож хэрэгжүүлэх.

Тус үйлдвэрийн газрын 2016 оны 09 дүгээр сараас 2017 оны 06 дугаар сарыг дуустал материалын зарцуулалтын тайлангаас АИ-92 шатахууны зарцуулалтын тооцоог тулган баталгаажуулахад захирлын автомашинд 7,710.5 мянган төгрөгийн, ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч нар 2,430.1 мянган төгрөгийн, бусад инженер, ажилчид 3,222.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Гэвч ерөнхий нягтлан бодогч болон инженер техникийн ажилтнууд маршрут гаргаж, захирлаар батлуулдаггүй бол захирал, ерөнхий инженерийн хэрэгцээний шатахууны зарцуулалт, маршрутыг зөвхөн ерөнхий нягтлан бодогчоор батлуулан шатахуун зарцуулж иржээ.

АИ-92 шатахууны зарцуулалтыг дэлгэрэнгүйгээр хүснэгтээр харуулбал:

Сар. Өдөр	Э.Эрдэнэбаатар		Ц.Мөнхдорж		Д.Ванчигмаа		Бусад		Зөрчил
	Хэмжээ /литр/	Дүн /мян.төг/	Хэмжээ /литр/	Дүн /мян.төг/	Хэмжээ /литр/	Дүн /мян.төг/	Хэмжээ /литр/	Дүн /мян.төг/	
2016.09 сар	603.78	856.3	64.1	90.9	96.15	136.3	428.22	607.3	Ерөнхий ня-бо, бусад
2016.10 сар	562.2	782.0			52.28	72.7	345.1	480.1	инженер, ажилчид нарын
2016.11 сар	664.9	924.8	164	228.1	115	159.9	115	160.0	шатахуун маршрут
2016.12 сар	741.2	1,030.9	163.4	227.3	105.1	146.1	217.57	302.6	байхгүй, нийт шатахуун
2017.01 сар	481	669.0	163.39	227.3	134.38	186.9	345.35	480.3	зарцуулсан жолоочийн
2017.02 сар	105	146.0					30	41.7	тооцооны хуудас байхгүй,
2017.03 сар	654.1	969.3	153.4	227.3			237.3	351.7	захирал, ерөнхий
2017.04 сар	590	874.3	122.7	181.8	45	66.7	147	217.8	инженерийн машины
2017.05 сар	610.9	905.2	153.4	227.2	79.75	118.2	145	214.9	маршрутыг ня-бо
2017.06 сар	373	552.7	30	44.4	60	88.9	247	366.0	баталсан, хэдэн км явахыг
Нийт дүн	5386.08	7,710.5	1014.39	1,454.3	687.66	975.7	2257.54	3,222.4	тодорхой тусгаж өгөөгүй.

Зөвлөмжийн биелэлт **30,0** хувьтай байна гэж үзэж байна.

Аудитын дүгнэлт

- Өмнөх аудитаар тавигдсан актыг барагдуулсан байна.
- Албан шаардлагын биелэлт **89,0** хувьтай байна.
- Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт өгөгдсөн зөвлөмжийн биелэлт **91,2** хувьтай байна.
- ОНӨААТҮГ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч нарт өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт **84,4** хувьтай байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

- Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын захирал Э.Эрдэнэбаатарт холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

ОНӨААТҮГ-ын захирал Э.Эрдэнэбаатарт:

- Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй ерөнхий нягтлан бодогч Д.Ванчигмаад холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.